



# ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

---

2020 оны 26-р долоо хоног

---

## ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 6-р сарын 19-өөс 6-р сарын 26-ны байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 15 дахь дугаарыг хүргэж байна.

### 1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- ОУВС “Дэлхийн эдийн засгийн төлөв” тайландаа КОВИД-19 цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөө оны эхний хагаст төсөөлснөөс илүү хүчтэй байж, сэргэлт оны сүүлийн хагаст алгуур бий болох хандлагатай болсон тул дэлхийн эдийн засгийн төлөв өмнөх төсөөллөөс муудсаныг онцоллоо. Тухайлбал, **ОУВС-аас 6-р сард хийсэн төсөөллөөр дэлхийн эдийн засаг 2020 онд 4.9 хувиар агшиж<sup>1</sup>**, өмнөх 4-р сарын төсөөллөөс 1.9 нэгж хувиар муудав. Суурь төсөөллөөр хөгжингүй орнуудын эдийн засаг 2020 онд 8 хувиар, хөгжиж буй орнуудын эдийн засаг 3 хувиар агших төлөвтэй байна. Дэлхийн эдийн засаг 2020 оны 2-р хагасаас эргэн сэргэж, 2021 онд хөгжингүй орнуудын эдийн засаг 4.8 хувь, хөгжиж буй орнуудын эдийн засаг 5.9 хувь өссөнөөр дэлхийн эдийн засаг 5.4 хувиар өсөх хүлээлт бий боллоо.
- ОУВС-ийн мэдээлснээр цар тахлын эсрэг засгийн газруудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн улмаас **дэлхийн нийт засгийн газрын өрийн хэмжээ 2020 онд анх удаа 100 хувийг давж, дэлхийн ДНБ-ий 101 хувьтай**

**тэнцэхээр байна.** Цар тахлаас үүдэлтэй хямралын улмаас засгийн газрууд нийт 10 гаруй их наяд ам.долларыг орлогын тасалдал, нэмэлт зардал, бизнесийн зээл, батлан даалт зэрэгт зарцуулаад байгаа юм.

- **Roubini Global Economics** байгууллагаас **дэлхийн эдийн засаг 2020 онд 4.0 хувиар агших** шинэчилсэн төсөөллийг 6-р сарын 12-нд зарлалаа. Энэ нь 5-р сард хийсэн төсөөллөөс 0.8 нэгж хувиар буурсан төсөөлөл юм. Суурь төсөөлөлд ирэх жилийн зун вакцин гарах хүртэл вирусийн тархалт хянагдахуйц түвшинд хадгалагдах, үйлдвэрлэл, хэрэглээ оны 2-р хагасаас сэргэх, төсөв, мөнгөний бодлогын үр дүнд эдийн засгийг дэмжихээр таамаглажээ. Харин муу хувилбараар бол зарим орнууд хөл хориог хэт эрт цуцалснаар КОВИД-19-ийн дэгдэлт дахин нэмэгдэж, W хэлбэрийн хямрал ажиглагдах бөгөөд бизнес, хэрэглээ, санхүүгийн хүлээлтэд сөргөөр нөлөөлж, дэлхийн эдийн засаг 2020 онд 4.5-6.5 хувиар агшиж 2022 оноос алгуур сэргэхэд хүрч болзошгүй гэж үзэж байна.

<sup>1</sup> IMF: [World Economic Outlook Update, June 2020](#)

- KPMG байгууллагаас дэлхийн эдийн засаг 2020 онд суурь төсөөллөөр 4.1 хувиар агших, гутранги хувилбараар<sup>2</sup> 7.9 хувиар агших төсөөллийг 6-р сарын 24-нд хийжээ. Суурь төсөөлөлд 2020 оны эхний хагаст дэлхийн эдийн засаг 11 хувиар агших бол сүүлийн хагаст эдийн засгийн үйл ажиллагаа сэргэнэ гэж үзжээ<sup>3</sup>.
- Bloomberg Economics-оос 6-р сард хийсэн төсөөллөөр дэлхийн эдийн засаг энэ онд 4.7 хувиар агшихаар байгаа бөгөөд 2021 оны 2-р хагаст цар тахлын өмнөх түвшинд эргэж очих боломжтой гэж тооцоолж байна<sup>4</sup>. Муу сценараар тархалт ахин дэгдэж, сэргэлт удаашрах тохиолдолд энэ онд дэлхийн эдийн засаг 6.7 хувиар агшиж, ирэх оны эцэст хямралын өмнөх түвшинд очиж болзошгүй байна.
- Евро-бүсийн голлох эдийн засгууд болох **Герман, Францын эдийн засаг потенциалын 85 хувиар ажиллаж**, эдийн засгийн идэвхжил алгуур сэргэх хүлээлттэй. Ийнхүү Евро-бүс болон АНУ-ын өмнөх саруудад агшилттай байсан PMI индекс 6-р сард өсөх төлөвтэй гэж Блүүмберг Экономиксийн судлаачид дүгнэж байна.
- **Английн Төв банкны Мөнгөний бодлогын хороо 6-р сарын 18-нд хуралдаж бодлогын хүүг 0.1 хувьд хэвээр хадгалах, бонд худалдан авах хөтөлбөрийн дүнг 100 тэрбум фунт стерлингээр нэмэгдүүлж**, оны эцэст нийт 745 тэрбум фунт стерлинг хүргэх шийдвэр гаргасан<sup>5</sup>. Английн төв банкны төсөөллөөр эдийн засагт алгуур сэргэлт ажиглагдаж, эдийн засгийн төлөв 5-р сарын хурлаас хойш дээрджээ. Иймд өнгөрсөн Пүрэв гарагаас эхлэн бонд худалдан авалтын хурдаа сааруулаад байна. Цаашид эдийн засгийн төлөв байдал хэрхэн өөрчлөгдөхөөс хамаарч инфляцын дунд хугацааны зорилт, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн нэмэлт арга хэмжээг авахад бэлэн байгаагаа Төв банк онцлов.
- **Оросын төв банк өнгөрсөн Баасан гарагт бодлогын хүүгээ 1 нэгж хувиар бууруулж, 4.5 хувь болгов**<sup>6</sup>. Оросын төв банкны төсөөллөөр энэ онд тус улсын эдийн засаг 4-6 хувиар агшиж, инфляц оны сүүл гэхэд зорилтот түвшин болох 4 хувь орчимд байхаар байна. Эдийн засагчид ОХУ-ын Төв банк энэ онд бодлогын хүүгээ дахин 0.5-1.0 нэгж хувиар бууруулах хүлээлттэй байна<sup>7</sup>.

<sup>2</sup> Муугаар тооцоолж буй хувилбарт тархалт ихэнх орнуудад дахин дэгдэж 2020 оны 3-р улиралд хэсэгчилсэн хөл хорио тогтоох таамаглалыг авч үзжээ.

<sup>3</sup> KPMG: [COVID-19 and the Global Economy](#)

<sup>4</sup> Блүүмберг: [Global Economic Output Won't Hit Pre-Crisis Level Until Mid-2021](#)

<sup>5</sup> Английн Төв банк: [Bank Rate maintained at 0.1% - June 2020](#)

<sup>6</sup> Оросын Төв банк: [The Bank of Russia cuts the key rate by 100 bp to 4.50% p.a.](#)

<sup>7</sup> Ройтерс: [Russia cuts rates to record low amid coronavirus crisis](#)

## 2 БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- **БНХАУ-ын аж үйлдвэрийн албан ёсны PMI индекс 5-р сард 50.4 хүрсэн бол 6-р сард 51 хүрч нэмэгдэх төлөвтэй**<sup>8</sup>. Экспортын өсөлтөд суурилсан Caixin PMI индекс өмнөх сарын 50.6-аас 6-р сард 51.2 хүрч, аж үйлдвэрийн бус PMI индекс 53.5-аас 54 хүрч тус тус сайжрах хүлээлттэй байна.
- **БНХАУ-ын PMI индекс 6-р сард улс орнууд хөл хорионы арга хэмжээгээ сулруулсан нөлөөгөөр нэмэгдсэн байх төлөв бий боллоо.** Том төслүүдийг дэмжих төсвийн зарцуулалт нэмэгдсэн нөлөөгөөр барилгын салбарын идэвхжил аж үйлдвэрлэлийн бус индексийн өсөлтөд түлхэц болох төлөвтэй байгаа ч тархалт БНХАУ-ын зарим хотуудад огцом нэмэгдсэн тул үйлчилгээний салбарын идэвхжил удаашрах хүлээлт давамгайлав.
- **БНХАУ-ын нийслэл Бээжин хотод КОВИД-19-ийн шинэ тохиолдлууд бүртгэгдсэнээр эдийн засгийн ирээдүйн төлөв, сэргэлтэд тодорхой бус байдлыг нэмэгдүүлсэн хэдий ч сөрөг үр нөлөө багатай байхаар байна.** Бээжин, Шанхай хотуудад метрогоор зорчигчдын түвшин цар тахлын өмнөх үеийн түвшний 60-70 хувь хүрч нэмэгдээд байсан бол Бээжин хотод шинэ тохиолдлууд бүртгэгдсэнээр тус хотод уг түвшин 40 хувьд хүрч буурлаа<sup>9</sup>. Харин Шанхай хотын нийтийн тээврийн хөдөлгөөнд бууралт ажиглагдаагүй байна. Эдийн засгийн идэвхжил нэмэгдэж байгаа ч дотоод эрэлт цар тахлын өмнөх түвшинд хүрэх харахан болоогүй байгааг Блүүмберг

<sup>8</sup> Блүүмберг: China Preview: PMIs to show wider manufacturing-services divide

<sup>9</sup> Блүүмберг: China Insight - Beijing's small virus burst casts big shadow

Экономиксийн шинжээчид онцолж байна.

- **ОУВС-аас 2020 оны 6-р сарын 18-ны байдлаар нийтэлсэн БНХАУ-ын Засгийн газраас КОВИД-19 цар тахалтай тэмцэхээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг дурдвал:**
  1. **БНХАУ-ын төсвийн бодлого:** БНХАУ-ын Ардын Их Хурлаар 2020 оны төсвийн алдагдлыг 3.6 хувь байхаар баталсан. Төсвийн бодлогын хүрээнд тусгай зориулалттай Засгийн газрын бондын арилжаа болон орон нутагт олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдээр дамжуулж 2020 онд БНХАУ-ын Засгийн газар 4.2 их наяд юанийн буюу ДНБ-ий 4.1 хувьтай тэнцэх төсвийн зарцуулалт хийхээ мэдэгдсэн. Тус зарцуулалт дараах 5 чиглэлийн хүрээнд хэрэгжихээр байна. Үүнд: 1) Ковид-19-ийн нөлөөг бууруулах, урьдчилан сэргийлэх, хяналтад оруулах, 2) эрүүл мэндийн багаж хэрэгслүүд үйлдвэрлэх, 3) ажилгүйдлийн тэтгэмж олголтыг идэвхжүүлэх, цагаач ажилчдын хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг сунгах, 4) татварын хөнгөлөлтийг үргэлжлүүлж, нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, 5) төсвийн хөрөнгийн зардлыг тэлэх зэрэгт зарцуулж байна.
  2. **БНХАУ-ын мөнгөний бодлого:** БНХАУ-ын Ардын Банк (ХАБ) энэ онд КОВИД-19-өөс үүдэн дотоод эдийн засагт ирэх дарамтыг саармагжуулахын тулд бодлогын хүүгээ 0.5-0.6 нэгж хувиар бууруулах хүлээлттэй байна<sup>10</sup>. Түүнчлэн, ХАБ дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

<sup>10</sup> ХАБ өмнө нь бодлогын хүүгээ 0.3-0.4 нэгж хувиар бууруулах хүлээлттэй байсан.

Үүнд 1) банкны хөрвөх чадварыг сайжруулах хүрээнд урвуу репо болон дунд хугацааны зээлийн хэрэгсэл зэрэг нээлттэй зах зээлийн хэрэгслүүдээр дамжуулан 5.1 их наяд юанийг нийлүүлээд буй, 2) эрүүл мэндийн багаж хэрэгслүүд, өдөр тутмын хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч бичил, жижиг, дунд үйлдвэрлэгчид болон хөдөө аж ахуйн салбарыг дэмжих зорилгоор 1.8 их наяд юанийн бага хүүтэй зээл олгоод буй 3) 7 болон 14 хоногийн урвуу репо хүүгийн түвшинг 30 нэгж хувиар, 1 жилийн хугацаатай зээлийн хүү, зорилтот зээлийн хүүг 20, 30 нэгжээр тус тус бууруулав. 4) 4 болон 5-р сард жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжих зорилгоор заавал байлгах нөөцийн хувийг хүртээмжтэй санхүүжилтийн тусгай шалгуур үзүүлэлтүүдийг хангаж буй /ЖДҮ-д зээл олгох/ том, дунд банкуудад 50-100 нэгж хувиар, шалгуур хангаж буй хоршоо банкуудад 100 нэгж хувиар, жижиг, дунд банкуудад 100 нэгж хувиар тус тус бууруулав, 5) илүүдэл нөөцөд ногдох хүүгийн хэмжээг 72 нэгж хувиас 35 нэгж хувь хүргэж бууруулсан, 6) хувийн компаниуд болон бичил, жижиг ААН-үүдэд олгох банкуудын зээлийн шугамыг өргөтгөсөн, 7) 400 тэрбум юанийн квоттой арилжааны банкуудын бичил, жижиг ААН-үүдэд олгосон зээлийг худалдаж авах шинэ бодлогын хэрэгсэл ашиглахаар болсноо мэдэгдсэн. Энэхүү шинэ хэрэгслээр дамжуулж ХАБ арилжааны банкуудын олгосон зээлийн 40 хувийг авах боловч зээлийн эрсдэлийг хүлээхгүй бөгөөд хүүгийн орлогыг авахгүй юм. Ингэснээр үндсэн зээлийн төлбөрийн 1 хувь буюу 40 тэрбум юаньтай тэнцэх дэмжлэг олгосноор, банкуудад шаардлага хангасан зээлийн төлбөрийн хугацааг

хойшлуулахад түлхэц өгөх зорилготой юм. Мөн цаашид дунд хугацааны зээлийн хүүг бууруулах, жижиг дунд бизнесүүдэд хөнгөлөлттэй зээлийн нөхцөлийг дэмжих зэрэг арга хэмжээг авах хүлээлттэй байна.

3. **БНХАУ-ын макро-санхүүгийн бодлого**<sup>11</sup>: БНХАУ-ын Засгийн газраас хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, эргэн төлөлтийн хүндрэлд ороод буй өрхүүд, компаниуд, бүс нутгуудад дэмжлэг үзүүлэх хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч байна. Үүнд 1) ЖДҮ-д зээл олголтыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд ЖДҮ-ийн зээлийг орон нутгийн банкуудаас барьцаа хөрөнгөгүйгээр авах боломжтой болгосон, том банкуудын бичил, жижиг зээлийн багцын өсөлтийн зорилтыг 30 хувиас 40 хувь хүргэж тус тус нэмэгдүүлэв; 2) зээл эргэн төлөлт хийх хугацааг 2021 оны 3-р сарыг дуустал хойшлуулан, цахимаар зээл авахад шаардагдах шалгуур үзүүлэлтүүдийг зөөлрүүлэн, хамрагдах боломжтой өрх, жижиг, дунд ААН-үүдэд олгох зээлийн дэмжлэгийн бусад арга хэмжээг нэвтрүүлж байна; 3) чанаргүй зээлийн өсөлтөд өндөр ач холбогдол өгөхгүй байж, чанаргүй зээлийн санд байршуулах ЗБН-ийн хэмжээ, шалгуурыг бууруулав; 4) бонд олголтыг нэмэгдүүлснээр жижиг, дунд ААН-үүдэд зээл олголтыг дэмжив, 5) хувийн компаниудын бонд гаргалтыг дэмжсэнээр компаниудад нэмэлт санхүүжилтийн дэмжлэг болох, энэ нь бондын хөрөнгө оруулалтыг даатгуулагчдад журмын шалгуур үзүүлэлтүүдийг сулруулав, 6) зээлийн баталгаанд зориулсан төсвийн дэмжлэгийг нэмэгдүүлэв, 7) активын удирдлагын зохицуулалтын шинэчлэлийн хэрэгжүүлэхэд уян хатан

<sup>11</sup> ОУВС: [Policy Responses to COVID-19](#)

байдлыг хангав, 8) орон нутгийн засаг захиргаанаас орон сууцны бодлогыг хөнгөвчлөх, шалгуурыг бууруулах зэрэг арга хэмжээ авч байна.

4. **Валютын ханш ба төлбөрийн тэнцэл:** Валютын ханш нь зах зээлийн зарчимд нийцтэй уян хатан байдлаар тогтох боломжтой болов. Макро-зохистой

бодлогын үнэлгээний хүрээнд санхүүжилтийн боломжит дээд түвшинг банкууд, ББСБ-ууд, ААН-үүдэд 25 хувиар тус тус нэмэгдүүлээд байна. Мөн гадаадын институционал хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтын квотын хэмжээний хязгаарлалтыг (QFII and RQII)-ыг цуцлав.


### 3 МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ

#### Гадаад худалдаа:

**Гадаад худалдааны эргэлт буурч, тэнцэл алдагдалтай гарлаа.**


2020 оны 6 дугаар сарын 15-ны байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1,696.6 сая ам.доллар (28.3%)-аар буурч, худалдааны тэнцэл 178.6 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад экспорт 1,331.5 сая ам.доллар (39.3%)-аар, импорт 365.0 сая ам.доллар (14.0%)-аар тус тус буурсан байна.

Зураг 1. Гадаад худалдааны эргэлтийн өсөлт, сараар



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Зураг 2. Экспорт, импорт, тухайн сараар



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

**Зөвхөн 5 дугаар сарын эхний 15 хоногт 186.2 сая ам.долларын экспорт, 194.4 сая ам.долларын импорт хийсэн байна. Энэ нь өмнөх 2 долоо хоногтой харьцуулахад харгалзан 88.1% буурч, 16.0%-иар өссөн үзүүлэлт байна.**


2020 он гарснаар зарим нэр төрлийн барааны экспортын гүйцэтгэл өмнөх оны мөн үеэс дараах байдлаар буурсан байна.

№	Барааны нэр	Экспорт		
		Тоо хэмжээ	сая \$	%
1	Зэсийн баяжмал	-73.0 мян.т	-306.2	-31.2
2	Алт	-3.1 т	-115.6	-59.0
3	Цайрын хүдэр, баяжмал	-6.1 мян.т	-25.7	-25.5
4	Чулуун нүүрс	-9.0 сая.т	-793.8	-56.9
5	Боловсруулаагүй газрын тос	-2.1 сая.баррель	-136.3	-82.7

Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

**Зээлийн тайлан:**

**Зураг 3. Зээлийн эргэн төлөлт, тэрбум төгрөг**




Эх сурвалж: Монголбанк

Банкуудын зээлийн өрийн үлдэгдлээс харахад КОВИД-19-ийн тархалтаас урьдчилан сэргийлж хөл хорио тогтоож эхэлсэн 2-р сараас хойш зээлийн чанар муудсан байна.

2020 оны 5 дугаар сарын тайлангаас харахад нийт зээлийн 84.1%-ийг хэвийн зээл, 6.9%-ийг хугацаа хэтэрсэн зээл, 9.1%-ийг чанаргүй зээл бүрдүүлсэн байна. Энэ нь зээлийн чанар муудсан буюу 1 дүгээр сартай харьцуулахад нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хэмжээ 2.4% буурч, хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 1.7%-иар өсөөд байна. Өөрөөр хэлбэл, хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 1 дүгээр сартай харьцуулахад 24.4% буюу 223.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

2020 он гарсаар тэтгэврийн зээлээс бусад зээлийн өрийн үлдэгдэл буурсан байна<sup>12</sup>. Тухайлбал 2019 оны 12 дугаар сард нийт зээлийн үлдэгдэл (тэтгэврийн зээл хассан)-ийн 11.4% буюу 1.97 их наяд төгрөгийн зээлийг эргэн төлсөн байна. Харин 2020 оны 5 дугаар сард энэ үзүүлэлт нь 10.4% болж буурчээ. Зээл олголтын хэмжээ 2019 оны 12 дугаар сард 1.99 их наяд төгрөг байсан бол 5 дугаар сард 1.75 их наяд төгрөг болж 12%-иар буурсан байна.


**Зураг 4. Банкуудын зээлийн үлдэгдэл, зээлийн ангиллаар**



Эх сурвалж: Монголбанк

**Хөрөнгийн зах зээл:**

**Зураг 5. Хөрөнгийн биржийн Топ-20 индекс**



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж


Монголын хөрөнгийн захын үргэлжилсэн уналтын эрч саарч бага зэрэг тогтворжих хандлагатай байна.

2020 оны 6 дугаар сарын 25-ны өдөр I, II, III ангиллын 15 хувьцаат компанийн 26,355,235 төгрөгийн үнийн дүн бүхий 492,994 ширхэг хувьцаа арилжигдсанаас 9 хувьцаат компанийн хувьцааны ханш өсч, 2 хувьцаат компанийн хувьцааны ханш буурсан бол 4 үнэт цаасны ханш тогтвортой байв. Улмаар ТОП-20 индексийн үзүүлэлт 1,6114.3 болж өнгөрсөн 7 хоногоос 1.3%, оны эхнээс 16.8%-иар буураад байна.

<sup>12</sup> МУ-ын Засгийн газраас тэтгэврийн зээлийг тэглэсэнтэй холбоотойгоор зээлийн эргэн төлөлтийн хэмжээ 2020 оны 2, 3 дугаар саруудад нэмэгдсэн тул тэтгэврийн зээлийг хасаж тооцоолов.

Монгол Улсын Засгийн газар, аж ахуй нэгжүүдийн гаргасан бондуудын өгөөж КОВИД-19 цар тахлаас шалтгаалж өсөөд байсан нь сүүлийн 1 сард харьцангуй тогтвортой байна.

Зураг 6. МУ-ын бондуудын өгөөж (%)



Эх сурвалж: Блүүмберг, Монголбанк



Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны ээлжит хурал 2020 оны 6 дугаар сарын 26-ны өдөр хуралдаж, дараах шийдвэрийг гаргалаа. Үүнд:

1) Эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв болон гадаад, дотоод орчны тодорхой бус байдлыг харгалзан үзээд бодлогын хүүг хэвээр хадгалах,

2) Банкны системийн тогтвортой байдлыг хангах үүднээс банкны эх үүсвэрийн долларжилтыг бууруулах, төгрөгийн харьцангуй өгөөжийг хадгалах зорилгоор өндөр хүүтэй гадаад валютын хадгаламж болон хүү төлж буй гадаад валютын харилцахын эзлэх хувиар банкинд олгох төгрөгийн заавал байлгах нөөцийн урамшууллыг бууруулан тооцох шийдвэрийг тус тус гаргалаа.

Олон улсын санхүүгийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-д үндэслэн Монголбанкнаас эдийн засгийг дэмжих санхүүжилтийн болон бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Жилийн инфляц 2020 оны 5 дугаар сард улсын хэмжээнд 3.3 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 3.5 хувьтай гарав.


Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийг даган дотоодын шатахууны үнэ буурсны зэрэгцээ эдийн засгийн өсөлт саарч, эрэлтийн шалтгаантай инфляц өсөхөөргүй, нийлүүлэлтийн шалтгаантай үнийн хэлбэлзэл үүсэхгүй тохиолдолд инфляц зорилтот түвшнээс бага байхаар хүлээгдэж байна.

КОВИД-19 халдвартай холбоотой гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнээс хойш авч хэрэгжүүлсэн төсөв, санхүү, мөнгөний бодлогын багц арга хэмжээ нь эдийн засгийн идэвхжилд эерэг нөлөө үзүүлж байна. Гэхдээ гадаад эрэлт болон эрдэс бүтээгдэхүүний үнэ буурч, КОВИД-19 вирусийн тархалтаас сэргийлэх хязгаарлалтын арга хэмжээ үргэлжилж, дотоод эрэлт эхний хагас жилд агшлаа. Энэ онд эдийн засгийн өсөлт саарч, инфляц нам түвшинд хадгалагдах хүлээлттэй байгаа боловч, эдийн засгийн дотоод, гадаад тэнцвэртэй байдлыг хангах шаардлага нь мөнгөний бодлогын төлөвийг цаашид зөөлрүүлэх боломжийг хязгаарлаж байна. Гадаад худалдааны маргаан үргэлжлэх, гадаад эрэлт, эрдэс бүтээгдэхүүний үнэ буурах зэрэг нь тодорхой бус байдал, эрсдэлийг нэмэгдүүлсээр байна.

## 5 ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭД ҮЗҮҮЛЖ БҮЙ НӨЛӨӨ

Өвчний тархалтыг бууруулах зорилгоор хэрэгжүүлж буй хориг арга хэмжээнүүд нь газрын тосны эрэлтийг огцом бууруулсан. Газрын тосны үйлдвэрлэлийн хэмжээг танах ОПЕК-ийн Өргөтгөсөн бүлгийн хэлцэл, мөн зарим улсад хориг арга хэмжээг аажмаар сулруулснаар, газрын тосны эрэлт буцаж сэргэсэн сүүлийн нэг сард газрын тосны үнэ өсөж 42 ам.долларт хүрлээ. Хятад улсад шинэ коронавирусийн тархалт намжиж, эдийн засаг нь идэвхжиж, үйлдвэрүүд нь үйл ажиллагаагаа сэргээсэн болон зарим гол зэс үйлдвэрлэгч улсуудад вирусийн халдвар эрчимтэй тархаж байгаа зэргээс шалтгаалан зэсийн ханш сүүлийн 3 сарын хугацаанд 28 хувиар өсөж 5,935 орчим ам.долларт хүрлээ. Харин сүүлийн 2 долоо хоногийн хугацаанд төмрийн хүдрийн үнэ хэлбэлзэл багатай, 103 ам.долларын орчимд тогтвортой байна. Шинэ коронавирусийн 2 дахь давлагаа эхэлж болзошгүй эрсдэлд байдал үүсэхтэй зэрэгцэн энэ долоо хоногт алтны ханш өсөж 1,780 ам.долларт хүрсэн нь сүүлийн 7 жилийн дээд үзүүлэлт боллоо.


Зураг 7. Зэсийн үнэ



Эх сурвалж: [www.investing.com](http://www.investing.com)

Зэсийн үнэ. Манай улсын гол экспортын бүтээгдэхүүнүүдийн нэг болох зэсийн үнэ шинэ коронавирусийн тархалттай холбоотойгоор огцом унасан бөгөөд 3 дугаар сарын 23-ны байдлаар 4,609 ам.долларт хүрч буурсан нь сүүлийн 4 жилийн хамгийн доод түвшин юм. Харин дэлхийн зэсийн эрэлтийн тал хувийг дангаар бүрдүүлдэг БНХАУ-н үйлдвэрүүд үйл ажиллагаагаа сэргээж, тус улсын зэсийн импорт огцом өссөнтэй холбоотойгоор сүүлийн гурван сарын хугацаанд зэсийн үнэ аажмаар буцаж сэргэн 5,935 ам.долларт хүрлээ. Энэ нь сүүлийн 5 сарын хугацаан дахь хамгийн өндөр үнийн түвшин юм. Нөгөө талаас, зэсийн гол нийлүүлэгч Чили, Перу зэрэг улсад коронавирусийн халдвар эрчимтэй тархаж буй нь зэсийн үнэ эргэж өсөхөд нөлөө үзүүлж байна.

Зураг 8. Газрын тосны үнэ




Эх сурвалж: [www.investing.com](http://www.investing.com)

Газрын тосны үнэ. 2020 оны эхэнд АНУ, Ираны зөрчлийн улмаас брент төрлийн газрын тосны ханш 70 орчим ам.долларт хүрсэн. Ковид-19 цар тахал дэлхийн олон оронд эрчимтэй тархаж, улс орнууд хориг, хариу арга хэмжээ авснаар дэлхийн аялал жуулчлал, тээврийн салбарын үйл ажиллагаа хумигдаж түлш, шатахууны эрэлт огцом буурсан. Нөгөө талд, томоохон газрын тос нийлүүлэгч ОХУ, Саудын Араб зэрэг улсууд үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх шийдвэр гаргасны улмаас дэлхийн зах зээл дээр газрын тосны илүүдэл үүсэж, 3 дугаар сард газрын тосны үнэ тасралтгүй буурсан. 5

дугаар сарын 1-ээс эхлэн ОПЕК-ийн Өргөтгөсөн бүлгийн газрын тосны гарц танах хэлэлцээр хэрэгжсэн. Мөн зарим улсууд хориг арга хэмжээгээ аажмаар сулруулж газрын тосны эрэлт буцаж сэргэж эхэлсэнтэй зэрэгцэн газрын тосны үнэ сүүлийн 2 сарын хугацаанд аажмаар өсөж 42 ам.долларт хүрлээ.


Зураг 9. Алтны ханш



**Алтны ханш.** Тодорхой бус байдал нэмэгдсэнтэй зэрэгцэн алтны ханш 2020 оны эхний улиралд 6.9 хувиар өссөн ба энэ нь 6 улирал дараалан алтны үнэ өссөн үзүүлэлт болж байна. 3 дугаар сарын эхэн үеэс БНХАУ-д вирусийн тархалт буурч, ихэнх улсуудын засгийн газар, төв банкууд КОВИД-19-ийн сөрөг үр нөлөөг бууруулах, эдийн засгаа дэмжих арга хэмжээг шийдэмгий авч эхэлсэнтэй холбоотойгоор алтны ханш 1,500 орчим ам.долларт хүрч огцом буурсан. Гэхдээ 4 дүгээр сараас

эхлэн дэлхийн улс орнуудад ээлжлэн вирусийн дэлхийн бусад улс орнуудад тархалт эрчимтэй нэмэгдсэн, АНУ болон Хятад улсуудын харилцаа таагүй байгаа зэргээс үүдэн глобал зах зээлд тодорхой бус байдлыг ихэсгэж алтны ханш өсч 1,700-1,750 ам.долларт хэлбэлзэж байна. Энэ нь 2019 оны мөн үетэй харьцуулахад 31 хувиар буюу 400 гаруй ам.доллараар өндөр үзүүлэлт юм.

Зураг 10. Төмрийн хүдрийн үнэ



**Төмрийн хүдрийн үнэ.** 2019 оны 11 сараас төмрийн хүдрийн ханш тасралтгүй өссөөр 2020 оны эхний сард 95 ам.долларт хүрсэн. Дэлхийн нийтэд төмрийн хүдрийн импортын 70%-ийг бүрдүүлдэг Хятад улсад КОВИД-19-н улмаас хөл хорио тогтоож, аж үйлдвэрүүд зогсонги байдалд орсон нь төмрийн хүдрийн эрэлт буурахад нөлөөлсөн. Ингэснээр 2 дугаар сарын эхэнд төмрийн хүдрийн үнэ 15.3 хувиар огцом унаж 78.3 ам.долларт хүрчээ. 4 дүгээр сард төмрийн хүдрийн үнэ харьцангуй тогтвортой 80-84

ам.долларын хооронд хэлбэлзэж байсан бол гол нийлүүлэгч улсуудад шинэ коронавирусийн халдвар хурдтай тархаж буйтай холбоотойгоор нийлүүлэлт тасалдаж байна. Тодруулбал, Бразил, Энэтхэг улсад вирусийн голомт төвлөрөн, эрчимтэй тархахтай зэрэгцэн төмрийн хүдрийн ханш сүүлийн нэг сар гаруй хугацаанд 25 хувиар чангарч 103 ам.долларт хүрлээ. Нөгөө талд, Хятад улсад гангийн үйлдвэрлэл сэргэж, төмрийн хүдрийн эрэлт их байгаа нь үнэ өсөхөд нөлөөлж байна.